*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 98 дугаар тушаалын 6 дугаар хавсралт*

ХАРХОРИН СУМЫН ЗДТГАЗАР *(нэгжийн нэр)-н* ХҮНС, ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛ ХОРШООНЫ АСУУДАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН (*албан тушаалын нэр*) ТӨМӨРБААТАР ОВОГТОЙ БЯМБАСҮРЭН (*албан хаагчийн овог, нэр*)-н 2024 ОНЫ СҮҮЛИЙН ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлт ийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилт 1. “Хүнс, худалдаа үйлчилгээ, хөнгөн үйлдвэрийн салбарын хууль тогтоомж, бодлого, шийдвэрийн хэрэгжилтийг хангаж, удирдан зохион байгуулна.”** | | | | | | | |
| 1. | Арга хэмжээ 1.1 Арга хэмжээ 1.1. Монгол Улсын Засгийн газрын болон Өвөрхангай аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, Өвөрхангай аймгийн 2024 оны хөгжлийн төлөвлөгөөнөөс суманд хамаарал бүхий заалтуудаас түүвэрлэн авч төлөвлөгөө гаргаж, үр дүнг тооцоон сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, сумын Засаг даргын Тамгын газарт тайлагнах. | Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь | 100% | 100% | Монгол Улсын Засгийн газрын болон Өвөрхангай аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, Хамтран ажиллах гэрээ, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, Өвөрхангай аймгийн 2024 оны хөгжлийн төлөвлөгөөнөөс суманд хамаарал бүхий заалтуудын биелэлтийг хугацаанд нь хүргүүлсэн.Ахуй үйлчилгээ, жижиг дунд үйлдвэр, мал аж ахуй, газар тариалан, аялал жуулчлал, барилга, хэвлэл мэдээлэл зэрэг чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа 510 иргэн 113 аж ахуй нэгжүүдийн дэлгэрэнгүй судалгаа | эхэлсэн: 2024.06.15 дууссан 2024.12.11 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | тусгай маягтын дагуу авч нэгтгэн мэдээллийн санд баяжилт хийлээ. | | |
| 2. | Арга хэмжээ 1.2. Арга хэмжээ 1.2. Тухайн орон нутгийн иргэдийн үүсгэн байгуулсан аж ахуйн нэгж, компанийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, гарааны бизнес эрхлэх, хөгжүүлэхэд чиглэсэн сургалтыг үе шаттай, тогтмол зохион байгуулах | Сургалтын тоо | 2 | 42 | Хоршоог хөгжүүлэх сангаас 2024 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн А/55 дугаар захирамжаар мах махан бүтээгдэхүүн ангилан ялгах, боловсруулах, малын тэжээл үйлдвэрлэл өргөтгөх чиглэлээр 2 хоршоонд 393,0 сая төгрөгийн зээл олгож 12 түр болон байнгын ажлын байр бий болсон.Шинэ хоршоо-Чинээлэг малчин хөдөлгөөний хүрээнд арилжааны банкаар дамжуулан 2,876,360,0 төгрөгийн зээлийг 19 хоршоонд малын тэжээл тариалах, хашаа саравч засварлах, малын үүлдэр угсааг сайжруулах, мал худалдаж авах, сүү сүүн бүтээгдэхүүн боловсруулах, арьс ширний анхан шатны боловсруулалтын чиглэлээр хөнгөлөлттэй зээлд хамрагдаж 76 ажлын байр хадгалагдсан Хөгжлийн шийдэл ТББ, Best хөтөлбөртэй хамтран "Хоршооны гишүүдийг чадваржуулах, хоршоог | эхэлсэн: 2024.06.15 дууссан 2024.12.11 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хөгжүүлэх сангийн журам, "Санхүүгийн боловсрол олгох, тайланг хэрхэн гаргах вэ? татварын ерөнхий ойлголт, НДШимтгэл, хоршоог хөгжүүлэх сангийн журам сэдэвт 2 удаагийн сургалтыг зохион байгуулж 78 иргэнийг хамруулллаа. | | |
| 3. | Арга хэмжээ 1.3. Сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа хүнсний худалдааны цэг, салбаруудаас 7 хоног бүр хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний нөөцийн мэдээг нэгтгэн авч, тухай бүр үнэн зөв бодитой мэдээлж, хангамж, нийлүүлэлтийн тэнцлийг үйлдвэрлэл, худалдааны тоо хэмжээнд үндэслэн улирал тутам бодитой тооцож ажилласан байх | Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь | 100% | 100% | Суманд үйл ажиллагаа явуулж байгаа модон эдлэл, оёдол, төмөр эдлэл, гурил, гурилан бүтээгдэхүүний чиглэлээр судалгаа сар бүрийн 20-ний дотор Өв аймгийн Статистикийн газарт аж үйлдвэрийн мэдээг хугацаанд нь хүргүүлсэн.Мэдээ тайланг хугацаанд нь үнэн зөв хүргүүлж байх талаар мэдээлэл 15-н нэр төрлийн хүнсний нөөцийн судалгааг 7 хоног бүр авч нэгтгэн ӨВХХАА-н газарт хүргүүлээд байгаа ба хүнсний нөөцийн хангалт 93.8%-тай байна. Сумын нөөцийн махыг төрөл тус бүрээр нь авч үзвэл адууны мах 2,1 тн, үхрийн ах 1,8тн, хонины мах 2,6 тн, ямааны мах 3 тн нийт 9,5тн нөөцийн | эхэлсэн: 2024.06.15 дууссан 2024.12.15 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | махтай байна | | |
| 4. | Арга хэмжээ 1.4. Хоршоог хөгжүүлэх сангийн төсөл зарлах, хүлээн авах, эргэн төлөлтийг хуваарийн дагуу төлүүлэх, мэдээллийн санд оруулж мэдээлэх, хяналт тавих, тайлагнах | 1.Зохион байгуулсан арга хэмжээний хувь | 2% | 2% | Сумын засаг даргын 2024 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн А/55 дугаар захирамжаар мах махан бүтээгдэхүүн ангилан ялгах, боловсруулах, малын тэжээл үйлдвэрлэл өргөтгөх чиглэлээр 2 хоршоонд 393,0 сая төгрөгийн зээл олгож 12 түр болон байнгын ажлын байр бий болсон. Сумын ИТХурлаас 2024 оны 04 дүгээр сарын 08-ний өдрийн хяналт шалгалт зохион байгуулах ажлын удирдамжийн дагуу төсөл хэрэгжүүлж байгаа иргэн, аж ахуй нэгжүүдэд явцын үнэлгээг тусгай маягтын дагуу хийж төслийн үр дүн, цаашид авах арга хэмжээний талаар мэдээлэл өгч ажилласан ба 98-%ийн биелэлттэй явагдаж 37 зээлдэгчийг бүрэн хаалгаж 25 зээлдэгчийн 41,2 сая төгрөгийн зээлийн ангиллыг солиулж хугацаа хэтрэлт 1,1 хувьтай болж зээлийн авлага 950,304,335 төгрөг, хүүгийн авлага 77,942,273 төгрөг, мөнгөн хөрөнгийн | эхэлсэн: 2024.06.05 дууссан 2024.12.11 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | үлдэгдэл 270,282,927 төгрөг байна. | | |
| **Зорилт 2. "Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх замаар хүн амын хэрэгцээ хангамжийг сайжруулах, хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг дээшлүүлнэ."** | | | | | | | |
| 1. | Арга хэмжээ 2.1. "Хөх сав, канистергүй сум, баг, өрх" хөдөлгөөн өрнүүлэх, малчдыг сүү цагаан идээгээ хүнсний зориулалтын саванд боловсруулах, хадгалах, тээвэрлэх чиглэлээр арга хэмжээ авах | -Нөлөөллийн арга хэмжээний тоо,<br><br>-Зориулалтын бус савыг зориулалтын саваар сольсон айл өрхийн тоо | Сумын хэмжээнд 180 айл өрх, 8 байгууллагын гал тогоо, 5 нийтийн хоолны газар хуванцар савнаас татгалзсан. | 2 | Өвөрхангай аймгийн Стандарт хэмжил зүйн газартай хамтран хоол үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээний газруудад ашиглагдаж байгаа хүнсний зориулалтын сав, гялгар уутыг хэрэглээнээс гаргах, хугацаа дууссан болон хаяг шошгын зөрчилтэй бүтээгдэхүүн худалдаалахыг хориглох чиглэлээр 2 удаа сургалт зохион байгуулж 49 иргэнийг хамруулан 213 ширхэг гарын авлага тарааж зөвлөн туслах үйл ажиллагааг зохион байгуулж ажиллалаа. Орон нутагт хүнсний чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй төсөвт байгууллага, иргэн, аж ахуйн нэгжүүдэд Стандарт хэмжил зүйн газраас баталсан Хүнсний бүтээгдэхүүний сав боодлын шошгололтод тавих шаардлага MNS6648:2016, Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газарт тавих шаардлага MNS4946:2019, Жижиглэн худалдааны газар, түүний үйлчилгээ MNS5021:2019 стандартуудыг танилцуулан | эхэлсэн: 2024.06.15 дууссан 2024.12.11 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | мөрдүүлж хэрэгжүүлэх арга хэмжээг авч ажиллаж байна. Мал тэжээвэр амьтад, хашаа, худгийн 2024 оны тооллого явуулах тухай сумын Засаг даргын захирамжийн дагуу Жалбаа багт ажиллаж 61 малчин өрхөд гарын авлага тараалаа. | | |
| 2. | Арга хэмжээ 2.2. Монгол улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар "Хүнсний хангамж, аюулгүй байдал" үндэсний хөдөлгөөн, УИХ-ын 2022 оны 36 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх, аймгийн Засаг даргын 2022 оны 606 дугаар захирамжаар батлагдсан хүнсний хангамж, аюулгүй байдлыг сайжруулах "Аймгийн 5 жилийн төлөвлөгөө"-ний хэрэгжилтийг орон нутагт зохион байгуулах | Төлөвлөгөөний хэрэгжилтийн тухайн жилийн үр дүнгээр | "Хүнсний хангамжийг нэмэгдүүлэх жил" болгон зарлаж 92%-тай хэрэгжүүлсэн. | | Өвөрхангай аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газраас зарласан "ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ" 6 сарын аяны хүрээнд хамтарсан хяналт шалгалт зөвлөн туслах арга хэмжээг зохион байгуулж нийтийн хоол үйлдвэрлэл эрхлэгч, ЕБСургууль, СӨББайгууллагын ажилчдад нийтийн хоол үйлдвэрлэлд тавигдах стандартын талаар сургалт зохион байгуулж 34 иргэнийг хамруулсан. Хүнсний худалдаа үйлчилгээ эрхлэгч иргэдэд "Боломж" хүнсний бөөний төвд үзүүлэх сургалт зохион байгуулж нийт 42 иргэнийг тус тус хамруулсан.Мөн сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа худалдаа үйлчилгээ, нийтийн хоол үйлдвэрлэл, хүнсний цехүүдийн 85%-д хяналт шалгалт зөвлөн туслах үйл ажиллагааг зохион байгуулж архи согтууруулах ундаагаар | эхэлсэн: 2024.06.15 дууссан 2024.12.11 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | үйлчлэх тусгай зөвшөөрөлгүй худалдаалж байсан 2 зөрчил, хадгалах хугацаа нь дууссан бүтээгдэхүүн худалдаалж байсан 5 зөрчлийг илрүүлэн торгуулийн арга хэмжээг авч ажилласан. | | |
| 3. | Арга хэмжээ 2.3. "Намрын ногоон өдрүүд-2024" улсын хэмжээний нэгдсэн арга хэмжээний хүрээнд сум орон нутагтаа үзэсгэлэн худалдаа зохион байгуулж, шалгарсан бүтээгдэхүүнийг улс, бүс, аймгийн үзэсгэлэн худалдаанд оролцуулахад дэмжлэг үзүүлэх | Аймаг, улс бүсийн үзэсгэлэнд 3 аж ахуй нэгж, 5 доошгүй иргэн оролцсон байна. | Үзэсгэлэн худалдаанд оролцох бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх, сурталчлах, дэмжлэг үзүүлж ажилласан байна. | | "Хархорины намар-2024" үзэсгэлэн худалдаа 09 дүгээр сарын 17, 18-ны өдрүүдэд зохион байгуулагдаж жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч 22 аж ахуйн нэгж, иргэн өрхийн үйлдвэрлэл, гар урлал, сүү сүүн бүтээгдэхүүн, төмс хүнсний ногоо, жимс жимсгэнэ зэрэг 16 нэр төрлөөр оролцож, 2 өдрийн хугацаанд нийт 20,0 гаруй сая төгрөгийн борлуулалт хийлээ. | эхэлсэн: 2024.06.15 дууссан 2024.12.15 | 100 |
| 4. | Арга хэмжээ 2.4. Хүнсний үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдэд дэмжлэг үзүүлж, хүнсний аюулгүй байдлыг хангах талаар хяналт шалгалт хийж, мэргэжил арга зүйн зөвлөгөө, заавар өгч хамтран ажиллах | Дэмжлэгт хамрагдсан үйлдвэр, аж ахуй нэгжийн тоо, дэмжлэгийн хэмжээ(төгрөгөөр) | 2023 онд жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сангаас 1 аж ахуй нэгжид 48,0 сая төгрөг Хоршоог хөгжүүлэх сангаас 1 хоршоо 10 иргэнд 263,0 | 2 хоршоонд 363,0 сая төгрөг олгосон | Өвөрхангай аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газраас зарласан "ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ" 6 сарын аяны хүрээнд хамтарсан хяналт шалгалт зөвлөн туслах арга хэмжээг зохион байгуулж нийтийн хоол үйлдвэрлэл эрхлэгч, ЕБСургууль, СӨББайгууллагын ажилчдад нийтийн хоол үйлдвэрлэлд | эхэлсэн: 2024.06.15 дууссан 2024.12.15 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон. | | тавигдах стандартын талаар сургалт зохион байгуулж 34 иргэнийг хамруулсан. Хүнсний худалдаа үйлчилгээ эрхлэгч иргэдэд "Боломж" хүнсний бөөний төвд үзүүлэх сургалт зохион байгуулж нийт 42 иргэнийг тус тус хамруулсан.Мөн сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа худалдаа үйлчилгээ, нийтийн хоол үйлдвэрлэл, хүнсний цехүүдийн 88%-д хяналт шалгалт зөвлөн туслах үйл ажиллагааг зохион байгуулж архи согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөлгүй худалдаалж байсан 2 зөрчил, хадгалах хугацаа нь дууссан бүтээгдэхүүн худалдаалж байсан 5 зөрчлийг илрүүлэн торгуулийн арга хэмжээг авч ажилласан. | | |
| 5. | Арга хэмжээ 2.5. Монгол үндэсний уламжлалт (орон нутгийн онцлогтой) хоол, идээ ундааг түгээн дэлгэрүүлж, хүнсний зохистой хэрэглээний талаар сургалт, сурталчилгаа, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулах | Зохион байгуулсан сургалтын тоогоор | 2 | 2 | Монгол үндэсний уламжлалт (орон нутгийн онцлогтой) хоол, идээ ундааг түгээн дэлгэрүүлж, хүнсний зохистой хэрэглээний талаар 2 удаагийн зурагт хуудас цахимд нийтлэн 90 гаруй иргэн үзсэн ба хүнсний худалдаа эрхлэгч нарт мэдээлэл өгсөн.Мөн "Шинэ хоршоо хөдөлгөө"-ний хүрээнд хоол хүнсний зохистой хэрэглээний талаар 18 малчин өрхүүдэд | эхэлсэн: 2024.06.15 дууссан 2024.12.11 | 95 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | мэдээлэл өгч ажиллалаа.Мал тэжээвэр амьтад, худгийн 2024 оны тооллогын комисст 6 дугаар багт ажиллаж 61 малчин өрхөд гарын авлага тараалаа. | | |
| **Зорилт 3. Холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон хэрэгжүүлж ажиллана.** | | | | | | | |
| 1. | Арга хэмжээ 3.1. Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх | Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь | 50% | 50% | Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулан эхний болон сүүлийн хагас жилийн төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэн ажилласан. | эхэлсэн: 2024.06.15 дууссан 2024.12.11 | 100 |
| 2. | Арга хэмжээ 3.2. Албан бичгийн боловсруулалтад Засгийн газрын 2020 оны 246 дугаар тогтоолоор батлагдсан "Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам", Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2021 оны С/30 дугаар тушаалаар батлагдсан MNS 5140-1:2021 баримт бичгийн стандартыг Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн санал хүсэлт, өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд нь шийдвэрлэн хариуг өгөх, шаардлагатай тохиолдолд холбогдох төрийн байгууллага, албан хаагчдаас тухай бүр тодруулга, мэдээлэл авч | Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь | 50% | 50% | Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журмыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ашиглаж Монгол улсын Их хурлаас 2020 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр баталсан Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай шинэчилсэн найруулгыг бие даан судалсан. "Хархоринд үйлдвэрлэв худалдааны төв"-д бараа бүтээгдэхүүнээ борлуулах хүсэлт гаргасан 1 иргэний өргөдлийг хүлээн авч Засаг даргын зөвлөлөөр | эхэлсэн: 2024.06.15 дууссан 2024.12.11 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | шийдвэрлэлтэд ахиц гаргах мөрдөж ажилласан байдал. | | | | шийдвэрлүүлсэн.Тайлант онд Тамхи худалдах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүссэн 23 аж ахуй нэгжийн хүсэлтийг хүлээн авч хуулийн хугацаанд шийдвэрлүүлэн ажилласан. ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж ямар нэгэн зөрчил дутагдалгүй ажилласан. Архи согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхтэй холбоотой тусгай зөвшөөрөл хүссэн 38 обектын хүсэлтийг худалдаа үйлчилгээний газруудаас хүлээн авч хүнсний хяналтын Улсын байцаагчтай хамтран ажиллаж дүгнэлт гаргуулан Өвөрхангай аймгийн Хууль эрх зүйн хэлтэст хүргүүлэн шийдвэрлүүлж 5 жилийн хугацаанд хамтран ажиллах хариуцлагын гэрээг байгуулан тусгай зөвшөөрлийг олгосон. | | |

**Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт**

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Арга хэмжээ 1. Бүх нийтийн хог цэвэрлэх ажилд хуваарийн дагуу оролцох | Оролцсон тоогоор | 1 | 1 | Бүх нийтийн хог цэвэрлэгээ зохион байгуулах ажлын хүрээнд 1 дүгээр багт хуваарийн дагуу ажиллаж айл | эхлэсэн: 2024.06 сар дууссан: 2024.12 сар | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | өрхүүдийг хог цэвэрлэгээнд хяналт тавин ажиллаж хариуцсан албан хаагчдад нь хүлээлгэн өгч иргэдийн санал хүсэлтийг тухай бүр нь танилцуулан ажилласан. | | |
| 2. | Арга хэмжээ 2.Бүх нийтийн мод тарих ажилд оролцох | Оролцсон тоогоор | 1 | 1 | Сумын хэмжээнд зохион байгуулсан бүх нийтийн мод тарих ажилд ажил үүргийн дагуу оролцсон. | эхэлсэн 2024.06 сар дууссан: 2024.12 сар | 100 |
| 3. | Арга хэмжээ 3.2024 оны Улсын Их хурлын 9 дэх удаагийн сонгууль зохион байгуулах ажилд ажиллах | Оролцсон тоогоор | 2 | 2. | 2024 оны Улсын Их хурлын 9 дэх удаагийн сонгууль, Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны ээлжит согуулиар Иргэний бүртгэлийн итгэмжлэгдсэн ажилтнаар 1-1-1Ↄ Ↄ дүгээр хэсэгт итгэмжлэгдсэн ажилтнаар тустус ажиллалаа. | эхэлсэн 2024.06сар дууссан: 2024.12 сар | 100 |
| 4 | Арга хэмжээ 4."Цахим шилжилтийг дэмжих жил"-ийн нээлтийн арга хэмжээнд оролцох | Оролцсон тоогоор | 1 | 1 | Сумын ЗДТГазар, зорилтот жилийн ажлын хэсгээс зохион байгуулсан "Цахимд хэвшье" сэдэвт нээлттэй хаалганы өдөрлөгт оролцож 18 иргэнд хүнс, жижиг дунд үйлдвэрлэл, шинэ хоршоо хөдөлгөөн, хоршооны журмын талаар мэдээлэл өгч ажилласан. | эхэлсэн2024 05 сар дууссан: 2024.05 сар | 100 |
| 5 | Мал тэжээвэр амьтад, хашаа, худгийн 2024 оны тооллого явуулах тухай 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн | Оролцсон тоогоор | 1 | 1 | Мал тэжээвэр амьтад, хашаа, худгийн 2024 оны тооллого явуулах тухай | эхэлсэн 2024.12.06 дууссан: | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | А/219 дүгээр захирамж | | | | сумын Засаг даргын захирамжийн дагуу Жалбаа багт ажиллаж байгаа ба 61 малчин өрхөд гарын авлага тараалаа. | 2024.12.17 | |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | Арга хэмжээ 1.1. Үйл ажиллагаандаа ашиглаж байгаа хууль тогтоомжуудыг судлан хууль эрх зүйн мэдлэгээ дээшлүүлэх. | Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь | 100% | 100% | Монгол улсын Их хурлаас 2012 оны 12 дугаар сарын 20-ний өдөр баталсан "Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль, Тамхины хяналтын тухай хууль, Зөвшөөрлийн тухай хууль, Хоршооны тухай хууль, Зээлийн батлан даалтын сангийн талаар эрх зүйн мэдлэгээ дээшлүүлж байна. | эхэлсэн: 2023.01.05 дууссан 2023.06.15 | 100 |
| 2. | Арга хэмжээ 2.1. Хоршоог хөгжүүлэх сангийн бүртгэл хяналтын нэгдсэн систем, ашиглах мэдлэгээ дээшлүүлэх, Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан онлайн семинарт хамрагдаж мэдлэгээ дээшлүүлэх. | Үндсэн арга хэмжээний гүйцэтгэлд эзлэх хувь | 100% | 100% | Монгол улсын Төрийн албаны зөвлөл, НҮБХХ, Монгол улсад мэргэжлийн, иргэн төвтэй төрийн албыг төлөвшүүлэх нь төсөлтэй хамтран зохион байгуулж байгаа Дижитал шилжилт виртуал орчинд ажиллах, Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн | эхэлсэн: 2024.06.15 дууссан 2024.12.11 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | танилцуулга, Төрийн албан хаагчийн үндэсний бичгийн мэдлэг тодорхойлох судалгаа, Монгол төрийн зүтгэлтний хэв шинж, Ёс зүйн дэд хорооны ажиллах журмыг хэрэгжүүлэх, Төрийн албан хаагчийн цалин хөлс нийгмийн баталгаа, Төрийн албан хаагчийн шинэтгэл ба цэгцрэх хөдөлгөөн, Монгол улсын Их хурлын сонгуулийн тухай хууль тогтоомжийг төрийн албан хаагч зөрчихөөс урьдчилан сэргийлэх нь, Төрийн албан хаагчийн ёс зүй, Төрийн албан хаагчийн цалин хөлс (орон нутгийн нэмэгдэл), Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр тэтгэмжийн тухай хуулийн хэрэгжилт, Монгол улс дахь Австралын тэтгэлэгт хөтөлбөрийн талаарх мэдээлэл, зөвлөмж, Гадаад улсын тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдах боломж үр дүн сэдэвт 14 удаагийн сургалтад хамрагдсан. Мөн 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр Өв аймагт “Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй” аяны хүрээнд Форум сургалтын төвөөс зохион байгуулсан сургалтад хамрагдаж сургагч багшийг сертификат | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | гардан авсан.Удирдлагын академи, Төрийн албаны сургууль, Төрийн инноваци хөгжлийн албанаас зохион байгуулсан "Төрийн захиргааны удирдах албан тушаалтны манлайлал" сэдэвт богино хугацааны сургалтад амжилттай хамрагдлаа. | | |

**ТАЙЛАН ГАРГАСАН:**

ХҮНС, ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛ ХОРШООНЫ АСУУДАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН ................................ / Т.БЯМБАСҮРЭН / 2024 он 12 дугаар сарын 11 өдөр

*( Албан тушаал )* *( Нэр, гарын үсэг )* *( Огноо )*